

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН  
ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ  
ХАГАС ЖИЛЭЭР ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ТАЙЛАН**


2024.06.20

Мандалговь хот

Аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх үнэлгээний баг томилох тухай” А/49 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний баг Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 301 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар “Аргачлал, загвар батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэлээ.

Байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэх үнэлгээний багт 6 сарын 15-17-ны өдрүүдэд 37 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээний хуудасны хамт ирснийг журмын дагуу үнэлгээний багийн гишүүд 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хуралдан албан хаагч бүрийн үнэлгээг хэлэлцэн үнэллээ.

Хэлтсүүдийн төрийн захиргааны албан хаагчдын үнэлгээг графикаар танилцуулбал:



Журмын дагуу маш сайн буюу хангалтгүй үнэлэгдсэн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтэд дахин үнэлгээ хийж цаашид

гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнахад анхаарах асуудлын талаар албан хаагч бүртэй уулзаж арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Хэлтсүүдийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулж батлуулахдаа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдаагүй, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн тусгаагүй, харьяа агентлагийн ажлыг тусгасан, бодлогын түвшний ажил нь тусгагдаагүй, үнэлгээг бодитой өгдөггүй зэрэг нийтлэг алдаа байсаар байна.

Тиймээс албан хаагчдыг төлөвлөлт, тайлагналтын чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах, бие даан судлуулах зэргээр мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээнд тусган үр дүнг бодитой тооцох шаардлагатай байна.

Тамгын газрын бодлого хариуцсан мэргэжилтнүүдийн энэ чиглэлийн чадавхыг сайжруулахгүй бол цаашид аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналтад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Тиймээс 2024 оны жилийн эцсийн ажил дүгнэхэд дээрх алдаа дутагдлыг засч төлөвлөлт, тайлагналтад хяналт тавьж, арга зүйн дэмжлэгээр ханган чанарыг сайжруулан үнэлгээг бодитой өгөхийг холбогдох хэлтсийн дарга нар анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.


#### Цаашид анхаарах зөвлөмж

- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа аймгийн бодлогын баримт бичгүүд, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөх
  - ✓ Арга хэмжээний хүрэх түвшинг нэг болон түүнээс олон шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлох /арга хэмжээг бүрэн хэмжиж чадахгүй байна/
  - ✓ Шалгуур үзүүлэлтийг үр дүнд суурилсан, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох
- Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжүүлэх эхлэх дуусах хугацааг сараар тооцох
- Төлөвлөсөн зорилт, арга хэмжээг тайлагнахдаа үйл явц бус үр дүнг илэрхийлэн /тоо баримттай өсөлт бууралттай/ 2000 тэмдэгтэд багтаах тайлагнах
- Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, тасралтгүй хөгжих зорилтыг төлөвлөхдөө 2-с дээш арга хэмжээг төлөвлөх бөгөөд тухайн албан тушаалд ажиллахад албан хаагчдад ямар ур чадвар шаардлагатай байна гэдгийг харгалзан үзэх

- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх үнэлгээг бодитой болгох
- Нэмэлт ажлын үнэлгээг өгөхдөө ажлын цар хүрээ, хэрэгжүүлсэн цаг хугацааг харгалзаж өгөх

Нэгжийн дарга нар дээрх зөвлөмжийг албан хаагчдадаа танилцуулан хэрэгжүүлж ажиллахыг хүсье.

Хянасан:

Үнэлгээний багийн дарга  Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга  Х.Мөнхсаруул

